

Цагаан Салаа-Бага Ойгорын хадны зураг дахь нарийн зураасан зураг

Мүшелханы Адилбек^{1,*}

Товч агуулга: Тус өгүүлэлд Монгол Алтайн баруун хэсэг Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутагт орших Цагаан Салаа-Бага Ойгорын хадны зураг дахь нарийн зураасан зургийн дүр дүрслэл, арга барил, сэдэв зохиомж, он цагийн хамаарал зэргийг харьцуулан авч үзэв. Эдгээр дурсгалт газарт хадны зурагт элбэг тохиолддог бугын дүрс, мөн хүний дүрс, тэрэгний дүрслэл зэргийг агуулсан нийт 78 нарийн зураасан зураг байна. Эдгээрийн дотор бидний шинээр олж илрүүлээд баримтжуулсан цөөнгүй зургийг хамруулсан болно. Он цагийн хувьд хүрэл зэвсгийн үеэс Түрэгийн үед хамаарах ажээ.

Түлхүүр үг: Нарийн зураасан зураг, хүрэл, түрүү төмрийн үе, түрэгийн үе

Удиртгал

Монгол орны хувьд хамгийн ихээр сийлсэн хадны зургийн нэгэн төрөл бол сийлмэл аргаар урласан зургууд юм. Харин зосон, хар бэхэн зураг тун ховор байдаг бол нарийн зураасан зургийн хувьд арай илүү түгээмэл гэж хэлж болохоор байна.

Монголын хадны зургийн эл дөрвөн арга барилаас Монгол Алтай баруун хэсэг Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт гурав нь илэрч олдсон байна. Тухайлбал, сийлмэл зураг хамгийн их, нарийн зураасан зураг нэлээдгүй илэрч байгаа бол зосон зургийн дурсгал одоогоор ганц дурсгал илэрч олджээ. Харин он цагийн хамааралын хувьд сийлмэл ба зосон зураг хамгийн эртний төрөлд багтдаг, харин нарийн зураасан зураг хүрлийн үеэс улбаатай гэж судлаачид үздэг юм (Цэвээндорж 1999: 142-146; Өмирбек 2019: 86-92).

Монгол Алтайн хадны зургийг судлах ажил эрчимтэй хийгдэж байгаа бөгөөд судалгааны үр дүнд хурц үзүүртэй, нарийн багажаар сийлсэн зургийг хадны зурагт нарийн зураасан зураг гэж бие даасан сэдэв болгон судлаад байна. Монгол Алтайн баруун хэсэг Билүүт, Шивээт хайрхан, Хойд Хөлцөөт, Цагаан салаа-Бага Ойгор, Хар магнай, Их Ойгор зэрэг томоохон хадны зургийн цогцолбор газруудад нарийн зураасан зургийн дурсгалууд ихээр илэрч байна.

Алтай нурууны тэр дундаа Цагаан салаа-Бага Ойгорын хадны зургийн судалгааг олон орны эрдэмтэн судлаачид олон арван жилийн турш хийж байгаа бөгөөд олон өгүүлэл, ном хэвлэн нийтлүүлсэн байна. Энэхүү дурсгалт газрыг анх академич Д.Цэвээндорж

нээн илрүүлж үүний дараа 1994 онд Монгол-Орос-Америкийн хамтарсан экспедиц Улаанхус сумын нутаг Цагаан Салаа-Бага Ойгор, Хар Ямаагийн хадны зургийн дурсгалыг илрүүлэн олж нягтлан судалжээ (Кубарев и др. 2005а).

Хадны зургийн дурсгалыг дүрсэлсэн арга барилаар нь сийлмэл зураг, зосон зураг, нарийн зураасан зураг хэмээн ерөнхийд нь ангилан үздэг бөгөөд харин нарийн зураасан зургийг тусгайлан судалсан нь тун цөөн юм. Харин Цагаан Салаагийн зураасан зургийн талаар нэрт эрдэмтэн академич Д.Цэвээндорж өөрийн бүтээлдээ дурдсан байдаг.

Монгол Алтайн баруун хэсэг Баян-Өлгий аймаг тэр дундаа хадны зургийн хамгийн томд тооцогддог Цагаан Салаа-Бага Ойгорын дурсгалт газарт гадаад дотоодын эрдэмтдээс бүрдсэн судалгааны ажил эрчимтэй хийгдэж байгаа бөгөөд Монгол-Оросын хамтарсан судалгааны баг Цагаан Салаа-Бага Ойгор, Хар ямаатын дурсгалт газруудад 2017 оноос хадны зургуудыг дахин нягталж бусад газрын тухайн үеийн дурсгалуудтай харьцуулан судлах зорилгоор нарийвчилсан судалгаа хийсэн байна (Батболд нар 2019).

Мөн МУИС-ийн Нүүдэлчдийн археологийн хүрээлэн “Монгол Алтайн хадны зургийн геоархеологийн судалгаа ба дижитал сэргээлт” төслийг 2022-2023 хэрэгжүүлсэн билээ (Төрбат нар 2023). Миний бие тус төслийн хүрээнд Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутагт орших Цагаан Салаа-Бага Ойгорын хадны зургийн дурсгалт газарт хийгдсэн хээрийн судалгаанд оролцон ажилласан юм. Үүнээс гадна сүүлийн 3-4 жилийн хугацаанд Монгол Алтайн хадны зургийн цогцолбор дурсгалт газруудад Дэлхийн өв-Монгол Алтайн хадны зургийн хамгаалалтын захиргаа мөн миний бие судалгааны ажлуудыг улирал тутамд үргэлжлүүлэн хийж байгаа бөгөөд судалгааны

¹ Дэлхийн өв-Монгол Алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа

* Холбоо барих зохиогч: adkaadilbek@gmail.com

явцад тус бүс нутгаас нарийн зураасан зураг шинээр нэг бус илэрч олдсоор байгаа болно. Иймээс эдгээр дурсгалыг олон нийтэд сурталчилан таниулах, шинжлэх ухааны эргэлтэнд оруулах шаардлагатай билээ.

Эх хэрэглэгдэхүүн

Цагаан Салаа-Бага Ойгорын хадны зурагт буй олон үед холбогдох нарийн зураасан зургийн дурсгал, дүрслэлийг энэ өгүүллийг бичих эх хэрэглэгдэхүүн болгон авч үзэв.

Цагаан-Салаа, Бага-Ойгорын хадны зургийн дурсгалт газар нь Монгол Улсын баруун хэсэг Монгол Алтайн нуруунд байрлана. Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутагт оршино. Энэхүү дурсгалт газар нь 2011 онд Дэлхийн өвд соёлын ангилалаар бүртгэгдсэн гурван газрын нэг юм.

Монгол Алтайн нурууны Цагаан Салаа-Бага Ойгорын хойт талын уулнаа олон тооны ан амьтан, мал, хүн, ан гөрөө, аж ахуй, дайн байлдаан хийж буй зэрэг олон тооны зургуудыг хонхойлон цоолборлох, гадна тэгийг хөвөөлөн цохих хадны зураг дахь үндсэн хоёр аргыг хэрэглэж урласны хамт хурц үзүүртэй багажаар зурсан нарийн зураасан зураг байна. Тус хадны зургийн цогцолбор дурсгал нь Бага Ойгор голын баруун, зүүн эргийн дагуу 15 км, мөн Цагаан Салаа-Бага Ойгорын зүүн эрэгтэй нийлсэн энгэр сугаар 1 км орчим дээш сунан үргэлжилсэн байдалтай оршино. Дурсгалт газрын хадны зураг нийт арван нэгэн секторт хуваагддаг үүнээс нарийн зураасан зураг нь Цагаан Салаа- I, Цагаан Салаа-II, Цагаан Салаа-IV мөн Бага Ойгор-II, Бага Ойгор-III, Бага Ойгор-V секторуудад байна.

Хэлэлцүүлэг

Монгол Алтайн баруун хэсэг болон дээрх дурсгалт газруудаас илэрсэн нарийн зураасан зургийг ажиглахад тоймлосон, өгүүлэмж, агуулга, зохиомж, мөн болхи дутуу зурагдсан хэлбэрээр илэрч байна. Зарим тохиолдолд эртний руни бичгийн дурсгалтай хамт, заримдаа эртний тамга тэмдгийн хамт тохиолдож байгаа нь нарийн багаж өөрөөр хэлбэл хадны зураг сийлэх багаж хэрэгслийн хөгжлийг харуулахаас гадна нийгмийн хөгжил дэвшлийг давхар харуулж байдаг.

Алтай нурууны хадны зургийн судалгааг олон орны эрдэмтэн судлаачид олон арван жилийн турш хийж байгаа бөгөөд олон өгүүлэл, ном хэвлэн нийтлүүлсэн байна.

Цагаан Салаа-Бага Ойгор уг дурсгалт газрыг судалсан эрдэмтэд нарийн зураасан зургийн дүрслэлүүдийг эртний түрэгийн үе зарим дүрслэлүүд

хожуу хүрлийн үед хамааран хэмээн судалгаа бүтээлдээ дурдсан байдаг.

Монгол орноос олдож буй нарийн зураасан зургийн хамгийн эртнийх нь палеолитын үе Хар чулуутын хадны зураг (Эрдэнэбат 2023), неолитын үе Хөрөөгийн үзүүрийн хадны зураг (Гантулга нар 2018) бололтой. Уг арга барилын үүссэн цаг хугацааны талаар судлаачид өөр өөр байр суурьтай байдаг. Ийм нарийн зураасан зургийн дурсгалуудын он цагийг тогтоох нь тун төвөгтэй учраас ихэвчлэн сийлсэн арга барил, хэв маягт нь анхаарч, түүнийг археологийн олдвортой харьцуулан харьцангуй он цагийг тогтоосоор байна. Нарийн зураасан зургийг бас дотор нь хэд хэдэн төрөл болгон ангилж болно. Үүнд; гадна тэгийг хөвөөлсөн, торлосон, сараачмал гэх мэтээр ангилна.

Нарийн зураасан зураг нь бие даасан хадны зургийн нэг төрөл боловч заримдаа сийлмэл зурагтай хосолмол аргаар, эсвэл эскиз маягаар дэвсгэр зураг хэлбэрээр тохиолдохоос гадна сийлмэл зургийн өгүүлэмж, сэдэв зохиомжтой ижил төсөөтэй дүрслэгдсэнийг бодвол “хосолмол”, “холимог” аргуудын нэг болов уу гэсэн таамаг төрүүлнэ. Хурц үзүүртэй, нарийн багажаар сийлсэн зургийг хадны зурагт ийнхүү нарийн зураасан зураг гэж бие даасан сэдэв болгон судлаад байна. Монгол Алтайн хадны зураг Билүүт, Шивээт хайрхан, Хойд Хөлцөөт, Цагаан Салаа-Бага Ойгор, Хар Магнай зэрэг томоохон хадны зургийн цогцолбор газруудад нарийн зураасан зургийн дурсгалууд ихээр илэрсэн байна.

Эдгээр хадны зураг дахь нарийн зураасан зургуудтай адил арга барил хэв маяг, зарим он цаг нь нэгэн үед холбогдох дүрслэлүүд (Зураг 2) хөрш зэргэлдээ орших ОХУ-ын Алтайн хадны Калбак-Таш I, Калбак-Таш II хэмээх газруудаас олдсон бөгөөд үүнийг судалсан судлаачид эртний Түрэгийн үед хамруулан авч үзжээ (Кубарев, 2011).

Судлаач Е.А.Окладникова Кара-Оюкийн нарийн зураасан зураг (Окладников, 1988) В.И.Елин Нарийн зураасан зургийн он цаг (Елин, 1994) Е.А.Миклашевич Скифийн үеийн нарийн зураасан зургийн арга техник, (Миклашевич, 2012) В.Д.Кубарев Калбак-Таш I дурсгалт газрын нарийн зураасан зургуудыг тусгайлан авч үзсэн байдаг (Кубарев, 2011) Мөн Г.В.Кубаревын Чуй (2004) болон Бичигт-Бом (Еркина, Кубарев 2004), Калбак-Таш II (2014) зэрэг дурсгалт газруудын скифийн үе, эртний түрэгийн үед холбогдох нарийн зураасан зургуудын судалгааг дурдаж болно.

Бид энэхүү өгүүлэлд Цагаан салаа-Бага Ойгорын хадны зурагт нарийн зураасаар саарчин, сийлж урласан бугын дүрс, хүний дүрс, адуу, тэрэг зэрэг шинээр олдсон зарим дүрслэлийн талаар авч үзэв.

Хүний дүрс. Хадны зурагт хүний дүрсийг янз янзаар зурсан хүний дүр ихээр тааралддаг. Анх неолит-

энеолитын үеэс зурж эхэлсэн гэж судлаачид үздэг.

Хадны зурагт Хэмцэгийн үед холбогдох нэгэн сонирхолтой дүрслэл дүрслэгдсэн байдаг. Хадны зурагт өнгөц харахад “хонх” хэлбэртэй, заримдаа “шувуу” ч гэмээр харагдах хүний дүрслэлийг судлаачид олон янзаар тайлбарлаж иржээ. Тухайлбал, “эвэртэй бодгаль - түрүү удган”, “нөмрөг ба эвэртэй хүн төрх дүр” (Кубарев и др. 2005b) “нөмрөгтөн” (Төрбат 2019), “бөөгийн хуяг” (Өмирбек 2019), түүнчлэн хонхон хэлбэрт хүн, шувуу хүн, бөө гэх зэргээр нэрлэжээ. Монгол Алтайн Цагаан Салаа-Бага Ойгор, Шивээт хайрхан, Хойд Хөлцөөт, Харганатын гол, Их Ойгор зэрэг хадны зургийн томхон дурсгалт газруудад нийтдээ 30 орчим “хуягт бөө”-гийн дүрслэл буй Хэмцэгийн соёлын хүний дүрслэл олдож байна (Өмирбек нар 2021). Миний бие судалгааны явцад үүнтэй яг ижил төстэй хурц үзүүртэй багаж ашиглаж нарийн зурсаар сийлсэн зургийг Цагаан Салаа-I дурсгалт газраас олж тэмдэглэсэн болно (Зураг 1).

Мөн Цагаан Салаа I талбайд байрлах Хүний эх бие хүзүү, хоёр хөл зэргийг хоёр зэрэглээ зураасаар, гар бэлгэ эрхтэн зэргийг ганц зураасаар тоймлон зуржээ. Харин нүд хөмсөг, хамар, ам, чихийг тодорхой зуржээ (Зураг 3). Хэдийгээр анчныг нэлээд загварчлан дүрсэлсэн боловч түүний нүүрний дүрс эртний Түрэгийн хүн чулууны нүүрний дүрслэлийн ерөнхий тигтэй төстэй байна хэмээн уг дурсгалыг судалсан эрдэмтэд үзжээ. Түрэгийн үед холбогдуулах үндэслэл нь зурсан арга барил техникийн шинжүүд, хүмүүсийн гээг үс, морины дэлийн засалт зэрэг нарийн угсаатны шинжийг харуулах дүрслэлийн шинжүүд (Төрбат нар 2009) байна. Хүн баруун гараараа эгэлдрэг, тохош, хударга бүхий морины цулбуураас хөтөлжээ. Хүн бугын нуруу дээд талаас дал руу нь том зүймэл нумаар харваж буйг тоймлон дүрсэлжээ.

Олон салаа шулуун эвэртэй бугын дүрийг тоймолсон байдалтай зураад дээгүүр нь олон шулуун зураасаар эгнүүлэн сараачжээ. Бугыг нарийн хоншоортой урт нарийн чихтэй дүрсэлжээ. Бугын хэвлий доор, мөн цээжин доор нь урт чихтэй, урт сүүлтэй хоёр чоно нохой мэт амьтны хорьж хоргоосон байдалтай зуржээ. Түүнтэй ижил нэгэн зохиомжинд оруулан нарийн зураасаар сийлж дүрсэлсэн зураасан зургийн дурсгал Хар магнайн хадны зурагт тааралдаж байна (Өмирбек 2014: 6). Хар магнай хэмээх дурсгалт газарт сийлсэн нум сумтай анчны бүснээс зүүсэн адууг нь мөн адилхан дөрөөгүй, эмээлтэй, хөмөлдөрөг, хударгатай сийлжээ. Түүнийг нохой дагуулан, ан агнаж байгаагаар дүрсэлжээ (Зураг 4).

Буга. Хадны зурагт бугын дүрсийг ихэвчлэн бодит, чимэглэсэн, загварчилсан хэв маягаар дүрсэлж урласан байдаг. Бугын дүрсийг заримдаа болхи болон бодит байдлаар их биеийг нь бүх талбайгаар нь цохиж цоолборлох, гадна тэгийг хөвөөлөн цохиж цоолборлох,

нарийн зураасаар зурах, сараачин, чимэглэх аргаар урласан нь тохиолдоно. Монгол Алтайн хадны зурагт нарийн зураасан зургаар загварчилсан бугыг сийлээд сараачин нарийн зураасаар торлосон тохиолдол илэрч байгаа билээ. Ийм дүрслэлүүд Монгол орны Баянхонгор аймгийн Зурагтын хад, Увс аймгийн Давст сумын зэрэг хэд хэдэн газрын хадны зурагт (Цэвээндорж 1999: 127) тааралддаг байна.

Цагаан Салаа-Бага Ойгорын дурсгалт газраас нарийн зураасаар сийлж урласан бугын дүрслэлүүдэд ихээр олдсон билээ: Үүнд:

TS-I-565-р хавтан нь уулын дунд хэсэгт баруун зүгт харсан хавтгай ургаа хадан дээр дүрслэгдсэн байна. Хадан дээр угалзарсан эвэртэй урт хүзүүтэй амьтны дүрсийг нарийн зураасаар сийлжээ. Уг амьтан нь зүүн тийшээ давхиж буй байдлаар харагдана, доторх зай хөндлөн олон зураас болон, шулуун ташуу зураасаар сийлж зурсан байна. Зургийн цаад талд буга хэлбэрийн дүрсийг маш бүдэг байдлаар дутуу нарийнхан сийлжээ (Зураг 5).

TS-I-650-р хавтан нь уулын дунд тэгшхэн хавтгай хадны дунд хэсэгт урд зүгт харуулан дүрсэлжээ. Нэгэн загварчилсан бугыг олон тасалсан нарийн зураасаар сийлжээ. Доод хэсэгт хүний дүрсийг хонхойлгон нэгэн тодорхойгүй дүрсийг хөвөөлөн дүрсэлжээ. Мөн хадны зүүн талд өөр нэгэн бугын дүрсийг нарийн зураасаар зурсан байна (Зураг 6).

TS-I-731. Энэ хаданд угалзарсан эвэртэй бүдүүн хүзүүтэй янгирыг нарийн зураасаар дутуу дүрсэлжээ. Урд хэсэгт нь олон хэлбэрээр сараачин сийлсэн байна (Зураг 7).

TS-I-732. Олон салаа эвэртэй нэгэн бугыг хурц үзүүртэй багажаар дүрсэлж доторх хэсгийг олон тасалсан зураасаар дүүргэжээ. Хажуу талд гараа алдалж, хөлөө алцайлган зогсож буйгаар хүний дүрсийг дүрсэлжээ (Зураг 6).

TS-II-1011) Цагаан Салаа-II өвөлжөөний баруун хойд талд хавтгай том хадны баруун талд ан агнуурын сэдэвт олон амьтан түүнийг зүймэл нум сумаар харваж буй анчдыг нарийн зураасаар тоймлон сийлжээ (Зураг 9)

TS-I-1012. Хадан дээр нэгэн том буга түүний араас харваж буй хүний дүрслэл доод хэсэгт гурван амьтныг нарийн зураасаар сийлжээ. Мөн хонхойлгон дүрсэлсэн хоёр зураг байна (Зураг 10).

BO-II-262. Зүүн зүгт харсан загварчилсан хос бугын дүрсийг гаднах тэгийг нарийн зураасаар зурсан байна. Дээд талд байгаа том бугын урт хоншоор хойд тал хондлой хэсгийг хонхойлгон цохиж дүрсэлжээ (Зураг 14).

BO-II-2461. Бага Ойгор-II дурсгалт газарт хоёр том буга түүний араас хөөж буй нохой, нум сумаар харваж буй анчин, морьтон зэргийг нарийн зураасаар сийлжээ. Палимпсест буюу дээр нь давхардуулан дарж сийлэх

аргаар зуржээ (Зураг 15).

ВО-IV-598. Хадны дээд хэсэгт зүүн зүг рүү харсан олон салаа эвэртэй гурван бугыг нарийн зураасаар дүрсэлжээ. Дунд хэсэгт эсрэг буюу баруун тийш харсан бугын олон салаа урт эврийг нарийн зураасаар, их биеийн доторх зайг сараачин дүрсэлжээ, доод хэсэгт эртний үхэр болон янгирыг хонхойлгон цохиж зуржээ (Зураг 16).

TS-I-1733. Хадны дунд хэсэгт урд зүгт харсан нэгэн адууг олон тасалсан нарийн зураасаар зуржээ (Зураг 11).

TS-I-916. Нэгэн адуу бололтой амьтныг нарийн зураасаар зурж доторх хэсгийг сараачин дүүргэжээ (Зураг 12).

Нарийн зураасан зургаар сийлсэн тэрэгний дүрслэл Монгол Алтайн баруун хэсэг болох Цагаан Салаа, Бага Ойгор, Шивээт хайрхан (Цэвээндорж нар 2010: 117), Хойд Хөлцөөтийн хадны зурагт дүрслэгдсэн (Өмирбек 2012: 91) байдаг. Зурсан арга барил, хэв маягийн хувьд нилээд болхи, дугуй болон хигээсийг гаргаж сийлсэн боловч зарим тоног хэрэгслийг сийлээгүй дутуу, маш болхи дүрсэлсэн байна. Хадны зурагт нарийн зураасаар сийлсэн тэрэгний дүрслэлийг маш муу урласан байдаг нь түгээмэл харагддаг билээ. Энэ үзэгдэл нь нарийн зураасан зурагт тэрэгний дүрсийг сайн урлаж буулгахад хэцүү, эсхүл зураачийн ур чадвар дутмаг бөгөөд зурахдаа хайнгадуу хандсан байж болох юм.

TS-I-1314. Цагаан Салаа-II талбайд хос дугуйтай тэрэгний дүрслэлийг нарийн зураасаар сийлжээ (Зураг 13).

Дүгнэлт

Энэхүү өгүүлэлд Монгол Алтайн баруун хэсэг Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт орших Цагаан Салаа-Бага Ойгорын хадны зургийн цогцолбор дурсгалт газруудын шинээр олдсон нарийн зураасан зургийн дүр, дүрслэлийг авч үзлээ.

Дээрх дурсгалт газруудаас илэрсэн нарийн зураасан зургийг ажиглахад 1) тоймлож зурсан, 2) өгүүлэмж агуулга бүхий, 3) зохиомжит хэлбэрийн, 4) болхи дутуу зурагдсан хэлбэрээр илэрч байна. Түүнчлэн зарим тохиолдолд эртний руни бичгийн дурсгалтай хамт, заримдаа эртний тамга тэмдгийн хамт тохиолддог.

Нарийн зураасан зургийг дотор нь: 1) гадна тэгийг нарийн зураасаар хөвөөлөн зурж сийлэх, 2) гадна тэгийг нарийн зураасаар хөвөөлөн сийлж, доторх талбайг нь ташуу зураасаар сийлж сараачих, 3) эх биеийг нь нарийн зураасаар будаж сийлэх аргуудыг ашиглан бүтээдэг байжээ.

Нарийн зураасан зургууд нь ихэвчлэн Монгол Алтайн хадны зураг Шивээт хайрхан, Хойд Хөлцөөт, Цагаан Салаа-Бага Ойгор, Билүүт, Хар Магнай зэрэг

томоохон дурсгалт газруудаас илрэн олдож байна. Дээр дурдсан дурсгалт газруудад нийт 52 хавтан дээр 201 дүрслэлийн талаар магистрын судалгааны ажилд оруулсан болно (Адилбек 2025). Эдгээр дурсгалт газруудад байгаа хадны зураг дахь нарийн зураасан зураг он цагийн хувьд түрүү хүрлийн үеэс эхлэх бөгөөд загварчилсан, чимэглэх аргаар бүтсэн зургууд нь хожуу хүрлийн үеэс түрүү төмрийн үед хамаарна. Зарим зураг сэдэв зохиомжийн хувьд түрүү дундад зуун буюу Түрэгийн үед хамаарна гэж он цагийн хүрээг нь тодорхойлов.

Нарийн зураасан зураг бие даасан хадны зургийн нэг боловч сийлмэл зургийн дэвсгэр буюу “эскиз” загвар зураг хэв маягаар анх хөгжсөн бололтой.

Abstract

Carved petroglyphs at the Tsagaan Salaa-Baga Oigor site

Mushyelkhan Adilbyek

This article examines the carved petroglyphs located at the Tsagaan Salaa-Baga Oigor site in the western part of the Mongol Altai, within the territory of Ulaankhus soum, Bayan-Ölgii province. The study presents a comparative analysis of the stylistic characteristics, carving techniques, thematic elements, and chronological context of the petroglyphs found at the site. A total of 78 petroglyphs, featuring common motifs such as deer, anthropomorphic figures, and carriages, were documented. Among them are several newly identified images. Stylistic and contextual evaluations suggest that the petroglyphs date from the Bronze Age through to the Turkic period.

Keywords: Carved petroglyphs, Bronze Age, Early Iron Age, Turkic period

Ном зүй

Батболд, Н., Молодин, В.И., Черемисин, Д.В., Ненахова, Ю.Н. (2019). Монголын баруун хойд бүс нутагт хийсэн хадны зургийн судалгаа. Археологийн судлал. Том XXXVIII, Fasc. 2. УБ.

Гантулга, Ж., Ерөөл-Эрдэнэ, Ч., Магай, Ж. (2018) Хөрөөгийн үзүүрийн хадны зургийн судалгаа. УБ.

Елин, В.И. (1994). Хронология граффити. Материалы по истории и культуре Республики Алтай. 55-57.

Өмирбек, Б., (2019) Баян-Өлгий аймгийн археологийн дурсгалууд. УБ.

Өмирбек, Б. (2014). Хар Магнайн хадны зураг. Ховд Их Сургууль., Түүхийн Товчоон. УБ..

Өмирбек, Б., Батболд, Н., & Цэрэндагва, Я. (2021). Дэлхийн өв-Монгол алтайн хадны зураг. УБ.

Окладников, Е.А. (1988). Граффити Кара-Оюка, Восточный Алтай (характеристика изобразительных особенностей и хронологии). Материальная и Духовная Культура Народов Сибири. Сборник Музея Антропологии и Этнографии. XLII.

Миклашевич, Е.А. (2012). Техника гравировки в наскальном искусстве скифского времени. Изобразительные и Технологические Традиции в Искусстве Северной и Центральной Азии. IX.: 157–202. М. - Кемерово.

Кубарев, В.Д., Цэвээндорж, Д., Якобсон, Э. (2005) Петроглифы Цагаан салаа и Бага Ойгура (Монгольский Алтай). Новосибирск: Изд-во ИАЭТ СО РАН. – 442 с.

Кубарев, В.Д. (2011). Петроглифы Калбак-Таш-I. - Новосибирск. - 242 т.

Төрбат, Ц., Баяр, Д., Цэвээндорж, Д., Баттулга, Ц., Баярхүү, Н., Идэрхангай, Т., Жискар, П.Х. (2009) Монгол Алтайн археологийн дурсгалууд-I: Баян-Өлгий аймаг. УБ..

Цэвээндорж, Д. (1999) Монголын эртний урлагийн түүх. УБ.

Цэвээндорж, Д., Кубарев, В.Д., Якобсон, Э. (2010) Шивээт хайрханы хадны зураг. УБ.

Эрдэнэбат, У. (2023) Хар чулуутын палеолитын хадны зураг. *Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology*, Vol. 12 (1), No. 1: 11-26


Received: May 19, 2025; Revised: May 23, 2025; Accepted: June 5, 2025




Зураг 1. Цагаан Салаа-I, Хэмцэгийн соёлын хүний дүрслэл




Зураг 2. Бага Ойгор-IV, Хэмцэгийн соёлын хүний дүрслэл ба янгир



Зураг 3. Цагаан Салаа-I,
(Кубарев, Цэвээндорж, Якобсон 2005)




Зураг 4. Хар Магнай
(Өмирбек 2014)




Зураг 5. Цагаан Салаа-I, 565




Зураг 6. Цагаан Салаа-I, 650




Зураг 7. Цагаан Салаа-I, 731




Зураг 8. Цагаан Салаа-I, 732



Зураг 9. Цагаан Салаа-II, 1011




Зураг 10. Цагаан Салаа-II, 1012




Зураг 11. Цагаан Салаа-I, 1733



Зураг 12. Цагаан Салаа-I, 916



Зураг 13. Цагаан Салаа-I, 1314



Зураг 14. Бага Ойгор-II, 262



Зураг 15. Бага Ойгор-I, 2461



Зураг 16. Бага Ойгор-IV, 598